

Гонзало Кастро де ла Мата
Дарга

IPN ХҮСЭЛТ RQ 15/03

2015 оны 3-р сарын 13

БҮРТГЭЛИЙН МЭДЭГДЭЛ

Хяналт шалгалт явуулах хүсэлт

Монгол Улсын уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх төсөл (MINIS) (P118109) болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх төслийн нэмэлт санхүүжилт (P145439)

Хяналт шалгалт явуулах хүсэлт

Монгол Улс болон ОХУ-ын орон нутгийн төлөөлөгчид болон орон нутгийн байгууллагууд “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх төсөл” (MINIS эсвэл “Төсөл”)-ийн зүгээс үзүүлэх боломжит хор хохирлын талаар ихээхэн сэтгэл зовинож буйгаа дурдан Хяналт шалгалт явуулах хүсэлтийг тус хороонд гаргасныг 2015 оны 2-р сарын 10-ны өдөр хүлээн аваад байна. Тэдгээр байгууллага болон хувь хүмүүс өөрсдийн хувийн мэдээллийг нууц байлгахыг хүссэн бөгөөд захидал харилцааг хүлээн авахын тулд “Хил хязгааргүй гол мөрөн” хэмээх байгууллагаас хоёр төлөөлөгчийг Монгол Улс болон ОХУ-д томилсон.

Төсөл

MINIS нь 2011 оны 5-р сарын 10-ны өдөр тус Банкны Гүйцэтгэх захирлуудын зөвлөл (“Зөвлөл”)-өөр батлагдаж, Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн 25 сая ам.долларын зээлээр санхүүжин 2016 онд дуусах төлөвлөгөөтэй байгаа техникийн туслалцааны үйл ажиллагааны төсөл юм. 2014 онд 4.2 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийг баталсан. Тус төслийн хөгжлийн зорилго нь “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран, уул уурхай, эцсийн шатны боловсруулалтын салбарт дэмжлэг үзүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, дэд бүтцийн төслийг бэлтгэх, явуулах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх”¹ явдал юм. MINIS нь 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Эдгээр нь (i) дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих, (ii) чадавхийг бэхжүүлэх, мэдлэг туршлагыг шилжүүлэх, (iii) гүний усны менежментийг

¹Уул уурхайн хөрөнгө оруулалтын дэд бүтцэд дэмжлэг үзүүлэх төсөлд зориулан Монгол Улсад олгохоор төлөвлөсөн зээлийн Төслийн үнэлгээний баримт бичиг, 2011 оны 4-р сарын 7 (PAD): 4

бэхжүүлэх, (iv) Төслийн удирдлага юм.² Бусад үйл ажиллагааны хүрээнд тус Төсөл нь санал болгож буй дэд бүтцийн дэд төслүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулалт, бэлтгэл ажлыг санхүүжүүлдэг.

Монгол Улсын Сангийн Яам уг Төслийн хэрэгжилтийг хариуцан ажиллана. Төслийг бэлтгэн боловсруулж, батлах үе шатанд MINIS-ийн дагуу дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлэх тодорхой төслүүд тодорхойлогдоогүй байх үед хөрөнгө санхүүгийн ашиглалтад хяналт тавих үүрэг бүхий Төслийн удирдах хороо үүсгэн байгуулагдсан болно. Төслийн гол анхаарч ажиллах салбар нь уул уурхайн салбар болон нөлөөллийн бүс (гол төлөв Монгол Улсын өмнөд хэсэг, гэхдээ бусад газар байрлалтай төслүүд мөн оролцож болно) дэх орон нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ерөнхий дэд бүтцийн салбар болно.

Энэхүү хүсэлт нь 1-р бүрэлдэхүүн хэсэгт гол төлөв хамаарах бөгөөд энэ нь уул уурхайн бодит чадамж дээр суурилан тухайн бүс нутгуудын дэд бүтцийн нэн тэргүүний эрэлт хэрэгцээг тодорхойлоход чиглэгдсэн Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах явдлыг дэмжиж байгаа юм. Түүнчлэн, тус төлөвлөгөөнүүд нь тодорхой хөрөнгө оруулалт эсвэл дэд төслүүдийн хувьд MINIS-ийн хүрээнд санхүүжүүлэх шаардлагатай ТЭЗҮ-нүүдийг тодорхойлно. Энэхүү төсөлд хамрагдах боломжтой салбаруудад эрчим хүч, тээвэр, МТ, харилцаа холбоо, ус, орон сууц, нийгмийн бүтээн байгуулалт, ложистик болон хилийн боомтын барилга байгууламжийн салбар багтана.

Төслийн үнэлгээний баримт бичигт (ТҮББ) дурдсаны дагуу хэрэгжүүлэлтийн явцад тодорхой дэд төслүүдийг тодорхойлох тул Банкны аюулгүй байдлын бодлогын талаар хийх хяналт шинжилгээг дэд төслийн түвшинд явуулах шаардлагатай болно. Бэлтгэл ажил болон үнэлгээний явцад зөвхөн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний бодлогын асуудлыг хөндсөн бөгөөд энэ нь дэд төслийн түвшний аюулгүй байдлын бодлогыг хөндөх шалгуурыг тодорхойлох, аюулгүй байдлын холбогдох шалгуурыг тогтоохын тулд “Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ” (БОНУХ)-г бэлтгэхэд хүргэсэн. Уг төслийг А ангиллын төсөл гэж ангилсан болно.

2014 оны 4-р сарын 14-ний өдөр Зөвлөл нь MINIS төслийн бүтцийг өөрчлөх асуудлыг баталсан.³ Төслийн хөгжлийн зорилтууд өөрчлөгдөөгүй боловч хамгаалалтын 5 нэмэлт бодлогыг боловсруулсан. Эдгээр нь Байгалийн амьдрах орчин, Соёлын биет нөөц, Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт, Далангийн аюулгүй байдал, Олон улсын усан зам зэрэг юм. Эдгээр нь сонгогдсон дэд төслүүдийн ТЭЗҮ-г бэлтгэх үе шатанд хамаарна. Мөн түүнчлэн БОНУХ-г шинэчилж, Төслийн гүний усны удирдлагын бүрэлдэхүүн хэсгийн түвшинг дээшлүүлсэн.

Хүсэлтэд дэвшүүлсэн асуудал

Уг хүсэлтэнд MINIS төслийн 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Банк нь Шүрэн усан цахилгаан станцын дэд төслийн урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ-г санхүүжүүлсэн бөгөөд ирээдүйд санхүүжүүлэх болно гэж дурджээ. Мөн түүнчлэн орон нутгийн иргэд болон байгаль орчинд

² PAD: 5.

³Уул уурхайн хөрөнгө оруулалтын дэд бүтцэд дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд Монгол Улсад явуулахаар санал болгосон бүтцийн өөрчлөлтийн талаарх Төслийн баримт бичиг, 2014 оны 3-р сарын 18.

сөрөг нөлөөлөл үзүүлж болох Орхон гол (Орхон-Говь усны гольдирол өөрчлөх төслийн баримт бичигт дурдсаны дагуу)-ын орон нутгийн болон урсацын зохицуулалтыг хийнэ гэжээ.

Хүсэлт гаргагчид мэдэгдэхдээ эдгээр дэд төсөл нь Банкны бодлогыг зөрчиж байгаа гэдгийг тодорхойлж үүний шалтгаан болгож сонгон шалгаруулах үйл явц ил тод бус явагдсан, эрсдэлийн болон хил дамнасан, нөлөөллийн давхардсан үнэлгээ зэрэг ижил төстэй үнэлгээн дээр суурилагүй гэжээ. Түүнчлэн, урьдчилсан ТЭЗҮ зэрэг Төслийн баримт бичгийг олон нийтэд танилцуулаагүй, иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй зөвлөлдөөгүй нь дэд төслүүдийг зохих шаардлагыг хангахгүй болгож байна гэж мэдэгдсэн байна.

Тэд нар яагаад Шүрэн усан цахилгаан станц, Орхон/Говь голын гольдирол өөрчлөх төслийг онцгойлон сонгосныг асууж байна. Учир нь Байгаль нуур – Сэлэнгэ мөрний экосистем нь “дэлхийн байгаль хамгааллын хамгийн чухал зүйл” болж байгаа ба Сэлэнгэ мөрөн, Орхон гол нь байгалийн чухал амьдрах орчин билээ. Түүнчлэн, Шүрэн усан цахилгаан станцын төсөл нь уул уурхайн салбартай шууд холбоотой биш гэж мэдэгдэж байна. Учир нь Өмнийн говийн уул уурхайн салбарын эрчим хүчний эх үүсвэрийн талаарх 2009 оны судалгаанд тус Банк уснаас цахилгаан гаргахыг уул уурхайн салбартай шууд холбоотой гэж үзээгүй болно.

Уг хүсэлтэд Шүрэн далан, Орхон/Говь голын гольдирол өөрчлөх төслийн Монгол Улс, ОХУ-ын иргэдэд үзүүлэх боломжит сөрөг нөлөөллийн талаар дурдсан байсан бөгөөд энэ нь усны амьтдын чөлөөтэй нүүдэлд саад учруулж, загасны тоо толгойг бууруулан, шим тэжээлтэй хөрс, чулуулгийн урсгалд саад болж, урсацын хэмжээг багасган, байгалийн усны температурт өөрчлөлт оруулж (эрүүл мэндийн эрсдэлийг бий болгоно), байгалийн чухал амьдрах орчны чанарыг бууруулан, хүлэмжийн хийн ялгаруулалтыг нэмэгдүүлж, Байгаль нуур (ЮНЕСКО-гийн Дэлхийн байгалийн өв газрын нэг)-т муу нөлөөлөл авчирна гэжээ. Түүнчлэн, хүсэлт гаргагчид уг хоёр төслийн зүгээс нийгэмд учруулах боломжит нөлөөллийг авч үзжээ. Үүнд Монголын өмнөд хэсгийн уламжлалт усан болон бэлчээрийн нөөцийг ашиглах боломжийг үгүй болгон, усан сан үерлэснээс үүдэж ургац, бэлчээрийн талбайг сүйтгэн, эко аялал жуулчлалын боломжийг ашиглах боломжгүй болгож, Байгаль нуур зэрэг соёлын үнэт өв бүхий археологийн болон ариун дагшин газрыг устгахад хүргэнэ гэжээ.

Уг хүсэлтэд тус Банк нь дараах бодлогыг биелүүлж ажиллаагүй байна гэж үзжээ. Үүнд: Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт, Байгалийн амьдрах орчин, Байгаль орчны үнэлгээ, Олон улсын усан зам, Мэдээлэл авах боломж, Усны нөөцийн менежмент, Сайн дурын бусаар нүүлгэн шилжүүлэх, Соёлын болон биет нөөц.

Хүсэлтийг бүртгүүлэх

Хороо нь уг хүсэлтийг бүртгүүлэх үндсэн шаардлагыг хангаж байна гэдгийг баталгаажуулсан: (i) уг хүсэлтийг Дэлхийн Банкны дэмжиж буй төсөлтэй холбогдуулан хоёроос доошгүй хүн хүргүүлсэн, (ii) Банкны санхүүжилт дуусаагүй байсан, эсвэл 95%-ийн зарцуулалтдаа хүрээгүй байсан (хүсэлтийг хүлээж авах үед уг Төсөлд ойролцоогоор 31%-ийн зарцуулалт хийсэн байсан), (iii) Хүсэлт гаргагчид Дэлхийн Банкны дэмжиж буй үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн гэдгээ баталсан, Хүсэлтэд тус Банкны дэмжиж буй үйл ажиллагаа болон Банкны үйлдэл, эс үйлдлээс хор хохирол учрах тухай асуудлыг дурдсан, (iv) Хүсэлт нь ханган нийлүүлэлттэй холбоогүй байсан (v) Хүсэлт нь Хорооноос өмнө нь санал зөвлөгөө өгч байгаагүй асуудалтай холбоотой байсан. Түүнчлэн, Хороо нь уг Хүсэлтийг

архивлахаас өмнө хэд хэдэн тохиолдолд Банкны анхааралд эдгээр санаа зовнисон асуудлыг хандуулна гэдгээ баталгаажуулж байна.

Төслийн үндсэн мэдээлэл болон хөндсөн асуудлыг шийдвэрлэхээр Банкны удирдлагын зүгээс гаргаж буй хүчин чармайлтыг сайтар ойлгохын тулд, уг Хороо нь 2015 оны 3-р сарын 6-нд Банкны удирдлагатай уулзсан. Удирдлага нь Хороонд мэдэгдэхдээ Төслийн удирдах хороо MINIS төслийн хүрээнд 6 дэд төслийг сонгосон гэжээ. Үүнд Шүрэн усан цахилгаан станц, Орхон Говь голын гольдирол өөрчлөх төсөл орсон. Сэлэнгэ мөрний ай савд хэрэгжүүлэх хоёр санал болгож буй төслийн боломжит нөлөөллийн талаарх Хүсэлт гаргагчийн санаа зовинолыг Удирдлага хүлээн зөвшөөрч байгаа ба ТЭЗҮ нь боломжит нөлөөллийн бүх хүрээг өргөн хүрээнд авч үзэж хариу өгөх болно гэдгийг онцолжээ. ТЭЗҮ-ний Ажлын удирдамжийг боловсруулж, 2015 оны 1-р сард олон нийттэй зөвлөлдсөн бөгөөд энэ үеэр олон асуудлыг хөндсөн. Эдгээр асуудлын ТЭЗҮ-ний хүрээнд шийдвэрлэж авч үзнэ гэдгээ Удирдлага мэдэгдсэн болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Шүрэн усан цахилгаан станц болон Орхон Говь голын гольдирол өөрчлөх төслийн боломжит нөлөөллийг урьдчилсан байдлаар авч үзсэн боловч дүгнэлт хийхэд шаардлагатай мэдээллийг ТЭЗҮ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр өгнө гэж Удирдлагын зүгээс нэмж хэлжээ.

Хорооны гаргасан Шийдвэр (“Шийдвэр”)-ийн 17-р зүйлд зааснаар *“Хорооны дарга нь хяналт шалгалт явуулах хүсэлтийг авсан даруйдаа Банкны гүйцэтгэх захирлууд болон Ерөнхийлөгчид мэдэгдэнэ”* гэжээ. “Миний бие 2015 оны 3-р сарын 13-ны өдөр буюу энэхүү мэдэгдлийг гаргасан өдөр би энэхүү Хүсэлтийг Хяналт шалгалтын хорооны бүртгэлд бүртгэсэн гэдгийг энэхүү мэдэгдлээр танд мэдэгдэж байна. Хороонд бүртгүүлнэ гэдэг нь Хяналт шалгалт явуулах Хүсэлтийн давуу талын талаар ямар нэгэн шийдвэр гаргана гэдгийг илэрхийлэхгүй. Шийдвэрийн 18-р зүйлд заасанчлан, *“Хяналт шалгалтын хорооны Зөвлөлийн хоёр дахь хяналтын дүгнэлт”*(1999 оны Тодруулга)-ийн 2 ба 8-т заасны дагуу Банкны удирдлага нь 2015 оны 4-р сарын 13-ны өдөр гэхэд Хяналт шалгалт явуулах Хүсэлтээр хөндсөн асуудалд Хариу ирүүлэх үүрэгтэй. Хүсэлтийн хариу болгож Удирдлагын холбогдон хийх шаардлагатай асуудлыг 1999 оны Тодруулгын 3 ба 4-р зүйлд заасан болно.

Удирдлагын Хариуг хүлээн авсны дараа, Хороо нь 1999 оны Тодруулгад заасны дагуу Шийдвэрийг 19-р зүйлд заасанчлан *“Хүсэлт нь [Шийдвэр]-ийн 12 ба 14-р зүйлд тавьсан эрхийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг шийдвэрлэж, энэхүү асуудлыг судлан шинжлэх талаар Гүйцэтгэх захирлуудад санал тавина”*.

Энэхүү Хүсэлттэй холбоотой явагдах бүх захидал харилцааг Хүсэлт гаргагчаас томилсон холбоо барих хүмүүст илгээж байх болно.

Уг Хүсэлтэд IPN Хүсэлтийн дугаар RQ 15/3-ийг оноов

Таныг Хүндэтгэсэн,

Дарга
Гонзало де ла Мата

Хавсралт

Олон Улсын Хөгжлийн Холбоо
Ерөнхийлөгч Жим Ён Ким

Олон Улсын Хөгжлийн Холбоо
Гүйцэтгэх захирлууд ба Орлогчид